# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Агуулга**

1. Аудитынгэрчилгээ ........ 2
2. Аудитын ТАЙЛАН ........ 4
2.1. Оршил ........ 4
2.2. Аудитхийхүндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 4
2.3. Аудитадмөрдсөнбодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт ........ 4
2.4. Байгууллагынзорилго,үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 7
2.12. Шилэн дансны мэдээлэл ........ 8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ........ 8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 8
3. Менежментийн ЗАХИДАЛ ........ 9
4.Аудит хийсэн САНХҮҮГИЙН тайлан ........ 11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 24

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ХХААХҮЯ | Хүнс, Хөдөө Аж Ахуй,Хөнгөн Үйлдвэрийн Яам |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн Газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/794
танай ____________-ны № ____________-т

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА М. ДОНДОГДОРЖ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0313SAG18.Docx

001051237

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0313SAG18.Docx

## 2. Аудитын ТАЙЛАН

2.1. **Оршил**

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын дарга М. Дондогдорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтын системийг боловсронгуйболгох нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтдаа үйл ажиллагааны онцлогтоо тохирсон зүйл заалтуудыг нэмж оруулах, автомашин, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийг бүрдүүлэн хөтлөж хэвших зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

**2.2. Аудитхийхүндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 13-наас 2020 оны 03 дугаар сарын 01–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн,Үндэсний аудитын газрын захиалгаар “Релаэнс секюритиз аудит”ХХК-ийн захирал Ж.Цэцэгмаа, аудитор С.Дашдондог,аудиторын туслах С.Золзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитадмөрдсөнбодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагынзорилго,үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Аймаг дундын отрын бүсийн бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах замаар мал сүргийг байгалийн гэнэтийн болон давагдашгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, оторчид, малчдад, төрийн үйлчилгээг үзүүлэх зорилготой.

Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны187 дугаар тогтоолоор Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа байгуулагдсан байна.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилгыг 2019 онд хэрэгжүүлж ажиллажээ. Үүнд:

- Отрын бүс нутгийн бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулахтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Отрын бүс нутгийн бэлчээрийн төлөв байдалд тандалт, хяналт үнэлгээ хийх замаар түүнийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, шинээр отрын нөөц бүс нутаг бий болгох ажлыг зохион байгуулах;
- Отрын бүс нутгийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулна;
- Отрын бүс нутагт өвс тэжээлийн нөөц бий болгож, мал сүргийн байгалийн эрсдэлийг даван туулах чадамжийг нэмэгдүүлнэ;
- Оторчдын нийгмийн ая тухтай нөхцөлийг хангах;

Өнөөгийн байдлаар Монгол улсын засгийн газраас мал сүргийг байгалийн болон гэнэтийн давагдашгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор 15 аймгийн газар нутгийг хамарсан 783.3 мян.га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч дараах 9 аймаг дундын отрын бүс нутгийг байгуулсан. Үүнд:

1. Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан /192.8 мян.га/
2. Говь-Алтай аймгийн Аргалант /118.6 мян.га/
3. Завхан аймгийн Багахайрхан /68.3 мян.га/
4. Говь-Сүмбэр аймгийн Малахын тал /73.1 мян.га/
5. Дорнод аймгийн Чойбалсан /124.4 мян.га/
6. Төв, Булган аймгийн “Чилэн” /34.1 мян.га/
7. Өвөрхангай, Төв аймгийн “Хөх дэл” /37.9 мян.га/
8. Увс аймаг Ачит нуурын /28.9 мян.га/
9. Ховд аймгийн Баяннуруу /105.2 мян.га/

Дээрх аймаг дундын отрын бүс нутгуудад жилд дунджаар 19 аймаг нийслэлийн 45 сум дүүргийн 700 гаруй өрхийн 600 орчим мянган толгой мал отроор өвөлжиж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Журам батлах тухай” МУЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол;

- “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” МУЗГ-ын 2019 оны 25 дугаар тогтоол;

- “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” МУЗГ-ын 2019 оны 24 дүгээр тогтоол;

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь ХХААХҮС-ын 2019 оны А385 дугаар тушаалын хавсралт "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд“Acolous”программ хангамж ашигладаг.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд 3горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АОУС 320, АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 830,370.6мянган төгрөгөөс 2.0 хувиар бодож 16,607.4 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

**2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 246,986.5 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 43,936.9 | 43,389.4 | (547.5) |
| Бараа материал | 21,438.4 | 34,480.2 | 13,041.8 |
| Үндсэн хөрөнгө | 3,330,503.1 | 3,071,022.3 | (259,480.8) |
| **Нийт хөрөнгө** | **3,395,878.4** | **3,148,891.9** | **(246,986.5)** |
| Засгийн газрын оруулсан капитал | 2,532,738.5 | 2,532,738.5 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 753,826.2 | 506,839.7 | (246,986.5) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 109,313.7 | 109,313.7 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3,395,878.4** | **3,148,891.9** | **(246,986.5)** |

Авлага дансны үлдэгдэл 547.5 мянган төгрөгөөр буурсан нь Швейцарийн агентлагийн "Ногоон алт,малын эрүүл мэнд төсөл"-өөс авсан санхүүжилтийн үлдэгдэл

буурснаас болсон.Тайлант оны эцэст уг төслийн авлагыг Сангийн яамны төрийн сангийн газартай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл13,041.8 мянган төгрөгөөр өсссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр Улсын онцгой байдлын комиссын захиалгаар ажлын хувцас 28,585.2 мянган төгрөг, түлш шатахуун 41,338.2 мянган төгрөгөөр бэлтгэсэн нь жилийн эцэст бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 259,480.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Швейцарийн "Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл"-өөс 55,000.0 мянган төгрөгийн Ланд 200 маркын автомашин, малын саравч 18,503.0 мянган төгрөгийн,нийт 73,503.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авч 349,396.1мянган төгрөгний үндсэн хөрөнгөд элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 376,061.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 372,591.2мянган төгрөг санхүүжилтээр авч, 3,470.0 төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:**

1. Хандив тусламжаар Швейцарын агентлагийн "Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл"-өөс 101,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр 57,610.7 мянган төгрөгийг зарцуулж үлдсэн 43,389.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, санхүү байдлын тайланд татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн.
2. ХХААХҮЯ-наас"Үлийн цагаан огтонотой байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх ажлыг аймаг дундын отрын бүс нутагт зохион байгуулах" ажлын санхүүжилт64,480.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр 64,479.6 мянган төгрөгийг зарцуулж үлдсэн 0.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

### 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл тодорхойлж нийт 3горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт10,850.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитын явцад залруулсан алдаа ньНҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Хүнс, Хөдөө Аж Ахуйн байгууллагаас тусламжаар авсан Ландкруйзер200 /4768убэ/автомашины гаалийн онцгой албан татварын 10,850.0 мянган төгрөгийг төсвийн эдийн засгийн ангиллаар буруу ангилан бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээгээр бүртгэснийг залруулсан.

Аудитаар илэрсэн дотоод хяналттай холбоотой 2 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

### 2.12. Шилэн дансны мэдээлэл

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 144мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нэмэгдэл цалин, хоол унааны хөнгөлөлтийн зөрүү 3,196.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 3. Менежментийн ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээ сурган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийгтабиднийхамтынажиллагааныбайрсууринаасгаргасанбөгөөдаудитаарөгсөнзөвлөмжийгхүлээнавч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1*** **Зардлын данстай холбоотой асуудал**

***1.1*** ***Илрүүлэлт:***
Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь ХХААХҮЯ-ны салбарын хэмжээнд мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгаа боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон зарим зүйл заалтууд тусгагдаагүй байна.Тухайлбал: 5.3.1-д бараа материал зарцуулалтын хэсэгт Улсын онцгой байдлын комиссоос өгсөн отрын бусад ажиллагсдад зориулсан хувцас, хэрэглэлийг ямар хугацаанд хэрэглэх, хангамжийн материал хэсэгт ямар бараа материал орохыг тодорхой заах.

***1.2*** **Эрсдэл:**

Бүртгэл тайлан алдаатай илэрхийлэгдэх эрсдэлтэй.

***1.3*** ***Өгсөн зөвлөмж:***
Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон зүйл заалтыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмж оруулах.

***1.4*** ***Байгууллагаас өгсөн хариу тайлбар:***
Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

***2.1*** ***Илрүүлэлт:***
Тээврийн хэрэгслийн техник ашиглалтын паспорт, хувийн хэрэг хөтлөөгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил,гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**2.2** **Эрсдэл:**

Өмч хөрөнгө үргэдэх, эзэнгүйдэх.

***2.3 Өгсөн зөвлөмж:***

2020 оны 1 дүгээр улиралд багтаан бүх автомашин, техник хэрэгсэлдээ техник ашиглалтын паспортыг хийж, хувийн хэрэг хөтлөх.

***2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:***

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Данс код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **65,375,310.00** | **77,869,610.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 00.00 |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 43,936,850.00 | 43,389,350.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 43,936,850.00 | 43,389,350.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 21,438,460.00 | 34,480,260.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 21,438,460.00 | 34,480,260.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 8,169,480.00 | 8,189,780.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,405,000.00 | 1,691,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 460,000.00 | 3,840,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,403,980.00 | 20,759,480.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,330,503,080.00** | **3,071,022,322.54** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 00.00 | 00.00 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,330,503,080.00 | 3,071,022,322.54 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,323,812,728.40 | 2,062,831,970.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,947,446,765.27 | 1,947,446,765.27 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -563,783,887.01 | -696,579,922.30 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 315,611,920.77 | 370,611,920.77 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -216,801,921.57 | -238,753,588.17 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 417,815,657.00 | 426,048,057.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -196,831,666.16 | -276,937,919.71 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 25,817,274.96 | 32,497,274.96 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,336,185.65 | -18,239,382.41 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,282,516,528.00 | 1,301,019,528.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -671,641,757.21 | -784,280,762.47 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 00.00 | 00.00 |
| 39217 | Ном | 00.00 | 00.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,006,690,351.60 | 1,008,190,351.60 |
| 39301 | Програм хангамж | 00.00 | 00.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 940,170.00 | 2,440,170.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -940,170.00 | -940,170.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,395,878,390.00** | **3,148,891,932.54** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 00.00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,395,878,390.00** | **3,148,891,932.54** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,395,878,390.00 | 3,148,891,932.54 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,532,738,464.28 | 2,532,738,464.28 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,526,048,112.68 | 1,526,048,112.68 |
| 51102 | - хувийн | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 51103 | - хувьцаат | 00.00 | 00.00 |
| 51104 | Халаасны хувьцаа | 00.00 | 00.00 |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | 00.00 | 00.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 1,006,690,351.60 | 1,006,690,351.60 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 753,826,228.25 | 506,839,770.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 753,826,228.25 | 753,826,228.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -246,986,457.46 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | 00.00 | 00.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 109,313,697.47 | 109,313,697.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,395,878,390.00** | **3,148,891,932.54** |

**4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 843,527,158.11 | 583,384,168.61 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | - | - |
| 110 | Орлогын албан татвар | - | - |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | - | - |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,150,000.00 | 41,842,668.61 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,150,000.00 | 41,842,668.61 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,100,000.00 | 41,842,668.61 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 5,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | - |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,100,000.00 | 41,837,668.61 |
| 120009 | Бусад орлого | 50,000.00 | - |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | - | - |
| 120011 | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/ | - | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 835,377,158.11 | 541,541,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 268,335,800.00 | 376,061,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 268,335,800.00 | 376,061,500.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | - |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | - |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | - |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | - | - |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | - | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 253,800,000.00 | 165,480,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 112,000,000.00 | 101,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 141,800,000.00 | 64,480,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | - |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 313,241,358.11 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 133003 | Хөрөнгийн | 313,241,358.11 | - |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 133005 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 888,804,395.54 | 830,370,626.07 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 871,495,322.29 | 815,757,180.37 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 871,495,322.29 | 815,757,180.37 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 126,920,511.00 | 143,570,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 94,583,211.00 | 105,494,600.00 |
| 210102 | Нэмэгдэл | 22,993,700.00 | 28,732,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,343,600.00 | 9,343,600.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,037,990.00 | 17,946,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,979,689.00 | 12,203,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,311,640.00 | 1,435,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 998,311.00 | 1,148,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 244,579.00 | 287,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,503,771.00 | 2,871,400.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,893,400.00 | 2,343,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 450,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | - | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | - |
| 210304 | Байрны түрээс | 1,893,400.00 | 1,893,400.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 45,728,254.75 | 23,817,340.34 |
